

МУЗЕЙН ЦУГЛУУЛГА ДАХЬ ГАЗРЫН ЗУРГИЙН ТӨРӨЛ ЗҮЙЛ НЬ ТҮҮХ, СОЁЛЫН ДУРСГАЛ БОЛОХ НЬ

Г.Энхбат
Д.Нарантуяа

Монголын Соёлын өвийн бүртгэл, мэдээллийн сан улсын болон аймаг орон нутгийн музейн сан хөмрөгт хадгалагдаж буй үзмэр, эд өлгийн зүйлсийг дараах үндсэн 6 төрөлд ангилан бүртгэдэг. Үүнд:

- Байгалийн дурсгал
- Археологийн дурсгал
- Түүх
- Угсаатны зүй
- Шашин шүтлэг
- Урлаг, уран сайхан болно.

Энэ удаагийн миний илтгэх гэж буй газрын зураг, өртөө, уул, ус, газар нутгийн холбогдолтой газар зүйн зураглал, тэмдэглэгээ бүхий үзмэр, эд өлгийн зүйл нь дээрх “Түүх”-ийн ангилал, тэр дотроо “Баримт бичгийн дурсгал” хэмээх төрөл зүйлд хамрагдаж цаас, даавуу зэрэг материал дээр хийсэн баримт бичгийн дурсгалууд бүхий бүртгэл-мэдээллийн санг бүрдүүлж байна.

Монгол Улсын Соёлын өвийг хамгаалах тухай хуулийн соёлын өв гэдэг тодорхойлолтод түүхэн тодорхой орон зай, цаг үеийн аль нэг хэсгийг төлөөлж чадах байгаль, нийгэм, түүх, соёл, урлаг, шинжлэх ухааны үнэ цэнэ, ач холбогдол бүхий эд өлгийг соёлын өв, түүх, соёлын дурсгалд тооцно хэмээн заасан байдаг.

Тэгвэл газрын зураг, газар дүрсийн тэмдэглэгээ, өртөө, харуулын чиглэл зэргийг цаас, даавуун дээр зурж тэмдэглэсэн баримт нь тухайн аймаг, хошууны хил хязгаар, газар, усны оноосон нэрийг түүхэн цаг үе, засаг захиргааны нэгжийн нэрийн хамт батлан үлдээсэн түүхэн ач холбогдолтой баримтат өв болохын сацуу уул, ус, газрын байршлыг тэмдэглэн зурж дүрслэхдээ монголын дүрслэх урлагийн уламжлалт хавтгай хэмжээст монгол зургийн аргаар өнгө будаг ялган зурсан байдгаараа уран сайхны соёл, урлаг, урлахуйн ухааны ач холбогдолтойг давхар нотлон харуулсан гэж үзэж болно.

Музей нь түүх, соёлын дурсгалд тооцогдох эд өлгийн зүйлийг цуглуулан хадгалахаас гадна олон нийтэд соёлын өвийн мэдлэг боловсрол олгох, үнэн бодит түүхийг мэдээлэх зэрэг олон талт үйл ажиллагаа явуулдаг.

Монгол зургийн хэлбэрээр зурсан газрын зурагт уул, усны нэрний соёл, түүний агуулга, угсаа гарвал зэрэг нь тухайн газрын байгалийн баялаг, эрдэнэсийг шууд утгаар нь нэрлэх, уул, ус газрын байршил, түүний харагдах хэлбэр төрхийг хүчирхэг амьтнаар бэлгэдэн дүрслэх, улсын болон орон нутгийн хилийн дээс цэгүүдийг тэмдэглэн үлдээсэн байдал нь улс, эх орны халдашгүй дархан байдлыг харуулсан гэх мэт олон төрлийн мэдээлэл газрын зургаас харж болно.

Г.Энхбат

Монголын Соёлын өвийн төв
enkhbat_cch@yahoo.com

Д.Нарантуяа

Монголын Соёлын өвийн төв
cch_fund@monheritage.mn

С.Чулуун, Э.Равдан, Х.Фүтаки, А.Камимүра

Монголын газрын зураг, газрын нэр судлал

“Адмон принт” ХХК хэвлэлийн газар. Улаанбаатар, 2015, ISBN 978-99973-0-702-6

Газрын зургаас бид Монгол орны түүхэн цаг үеүүдэд засаг захиргааны нэгжийн хувиарлалт хэрхэн хийгдэж байсан, энэ нь улс, төр, нийгэм, эдийн засаг, байгаль газар зүй, мал аж ахуй, нүүдэлчдийн соёлын хувьд ямар ач холбогдолтой, онцлог шинжтэй байсан талаарх мэдээллийг харьцуулах, хувь хүн өөрийн ураг, овог угсааны гарлын талаар мэдлэг олж авах зэрэг олон талын мэдээлэл, мэдлэгийг олж авах боломжтой юм.

Монголын музейнүүдийн сан хөмрөгт монгол орны эрт болоод эдүгээ үеийн газар зүйн зураглалтай холбогдолтой үзмэр, эд өлгийн зүйл цөөнгүй бий. Соёлын өвийн Улсын нэгдсэн бүртгэл, мэдээллийн санд 2015 оны 4 дүгээр сарын байдлаар музейнүүдээс 173 газрын зураг бүхий үзмэр бүртгэгджээ.

Музейн сан хөмрөг цуглуулга дахь газрын зургийн бүртгэлүүдээс үзэхэд 1921 оны Ардын хувьсгалаас өмнөх үеийн монгол орны нийгмийн байгуулалт, засаг захиргааны нэгжийг харуулсан газрын зураг нэн ховор байна.

Ихэнх музейн хувьд үзэгчдийн танин мэдэхүй, түүхийн боловсролд зориулан Монгол нутагт оршин байсан эртний улсууд болох Хүннү, Сяньби, Жужан, Түрэг, Уйгар, Кидан, Чингисийн үеийн монгол орон, түүний байлдан байгуулал, Их Юан гүрний үеийн нутаг дэвсгэр хил хязгаарын газрын зургийг орчин үед сэргээн зурсныг дэлгэн үзүүлж байна.

XVI зууны дунд үеэс XX зууны эхэн үе хүртэл буюу монгол оронд Бурханы шашин хүчтэй дэлгэрснээр томоохон хүрээ хийдүүд олноор байгуулагдан шашны суурин газрууд бий болжээ. Энэ цаг үеийн монголын засаг захиргааны нэгж болох хошуу нутгийн хил хязгаарын газрын зураг болоод томоохон хүрээ хийдүүдийн байршлын газрын зураг эх хувь байдлаараа маш цөөн тоогоор хадгалагдаж байна.

Музейн сан хөмрөгт хадгалагдаж байгаа эртнийд тооцогдох газрын зураг XVII зууны үед хамаарах “Боржигин сэцэн вангийн хошууны зураг”, “Дайчин бэйсийн хошууны нутгийн хилийн газрын зураг” зэрэг даавуун дээр хар бэхээр зурсан хошуу нутгийн хилийн газрын зураг эх хувь байдлаар Дундговь аймгийн музейн сан хөмрөгт бий.

Богд хааны ордон музейд хадгалагдаж байгаа Л.Жүгдэрийн 1912 онд зурсан “Нийслэл хүрээ” хэмээх зураг нь XX зууны эхэн үеийн монголын нийслэл хотын байдлыг бүрэн харуулсан юм. Уг зураг нь “монгол уран зураг”-ийн төрөл зүйлд хамаарах хэдий ч Богд хаант Монгол улсын үеийн Нийслэл хотын ойр орчмын уул, гол ус, газар орон хийгээд хотын гудамж, аймаг, хүрээ хийдүүдийг нэгбүр бүдүүвчилсэн план зургийн хэлбэрээр зурж, дээр нь тэдгээрийн нэрийг монгол бичгээр бичжээ. XX зуун эхэн үеийн монголын Нийслэл хотыг газар зүйн зураглал талаас бүрэн харуулсан түүх, соёлын өндөр ач холбогдолтой баримтат өв дурсгал юм.

Зураач Б.Шарав (1869-1939) нь 1911-1912 оны үед “Богдын ногоон ордон”, “Хайстай лаврин” хэмээх уран зургийг зурсан байна. Эдгээр зурагт шашин, төрийг хослон баригч VIII Богд хааны амьдарч байсан өвөл, зуны ордны байршил, байгууламжуудын хэв загвар, дүр төрх болон ойр орчмын газар нутгийн байдал, уул толгод, гол ус, ахуй амьдралыг дүрслэсэн байдаг. Өдгөө VIII Богд хааны зуны ордон Хайстай лаврин устаж үгүй болсон ба бид энэхүү зургаас уг ордны анхны төрх байдал, хэв загварын талаар мэдэж авах боломжтой.

XX зууны эхэн үеэс өмнөх Монголын засаг захиргаа, хошуу нутгийн хил хязгаар, өртөө харуул, томоохон хүрээ хийдүүдийн байршлын газрын зураг, холбогдох түүхэн баримт сурвалж нь ихэнхдээ Үндэсний архивын газар, Тагнуулын ерөнхий газрын архивт хадгалагдаж байна. Тухайлбал: 1937 оны хэлмэгдүүлэлтийн үед сүм хийдүүдийг нураахын өмнө тэдгээрийн байршил зүйн зургийг гараар үйлдэн авсан нь өдгөө Тагнуулын ерөнхий газрын Тусгай архивт хадгалагддаг.

1921 онд Ардын хувьсгал ялснаар монгол орны нийгэм, эдийн засгийн байгуулал шинэ шатанд шилжиж боловсрол, соёл, шинжлэх ухааны салбаруудын хөгжлийн суурь тавигдсан.

Ардын хувьсгал ялсны дараахан Ардыг гэгээрүүлэх яамны захиалгаар 1924 оны үед Герман улсад хэвлүүлсэн тухайн үеийн Монгол орны засаг захиргааны нэгжийн газар зүйн зураглал Дорнод, Хөвсгөл аймгийн музейд, мөн 1927 оны Монгол орны газрын зураг Орхон аймгийн музейд байна.

Монголд орчин цагийн газар зүйн зураглал хөгжихөд оросын судлаач, эрдэмтэн А.Д.Симуков (монголчуудын дунд шар Дамдинсүрэн хэмээн алдаршсан)-ын гүйцэтгэсэн үүрэг нэн их. Тэрээр 1923-1926 онд СССР-ийн Ардын Комиссариатын газраас санаачлан санхүүжүүлж П.К.Козловын удирдсан Оросын газарзүйн нийгэмлэгийн хээрийн хайгуулын ангийн бүрэлдэхүүнд байсан ба 1926 оны намраас эхлэн Монголын Судар бичгийн хүрээлэнд ажиллаж, 1927-1939 онд монгол орноор аялан хээрийн шинжилгээний ангид ажиллаж байжээ.

А.Д.Симуков хангай, говийн нутгийн физик-газарзүйн судалгаа хийж газрын зураг дээр анх удаа хэд хэдэн уул нурууг тэмдэглэн буулгаж, Монгол нутгийн байгалийн үндсэн бүсүүдийг тодорхойлон, бүсийн үндсэн ургамал, амьтныгтархац зэргийн газрын зураг гаргасан байна. Түүний хийсэн “БНМАУ-ын газарзүйн атлас” Улаанбаатарт 1934 онд, Монголд “Симуковын ногоон” гэж олноо алдаршсан “БНМАУ-ын ерөнхий газрын зураг” Улаанбаатарт 1937 онд хэвлэгдсэн газарзүйн зургууд өдгөө Байгалийн түүхийн музей, Монголын Үндэсний музей, Орхон, Өмнөговь аймгийн музейд хадгалагдаж, үзэгч олны хүртээл болсоор байна.

Социализмийн жилүүдэд нийгэм, эдийн засгийн олон салбаруудын хөгжлийг харуулсан төрөл бүрийн газар зүйн зураглал монголын музейн сан хөмрөг дэх газрын зургийн холбогдолтой үзмэрүүдийн дийлэнх хэсгийг эзэлж байгаа юм. Монголорны аймаг, нийслэл, сум, дүүрэг засаг захиргааны нэгжийн хувиарлалт, хүн ам угсаатны зүй, газар зүйн бүс, ашигт малтмал, амьтан, ургамалжилтын тархалт, хөдөө аж ахуй, газар тариалан, аж үйлдвэржилт, аялал жуулчлал, зам харилцаа тээвэр гэх зэрэг нийгмийн өргөн салбарыг хамардаг.

Сүүлийн үед музейнүүд өөрийн аймаг, орон нутгийн эртний засаг захиргааны нэгжийн хил хязгаар, өртөө харуулыг харуулсан сэргээн хуулбарлан зурсан, хэвлэсэн газрын зургаар сан хөмрөгөө баяжуулах болжээ.

Музейн сан хөмрөгт байгаа газрын зураг бүхий үзмэр, эд өлгийн судалгааг нарийвчлан тэдгээрийг төрөлжүүлэн ангилах, сэргээн засварлах, ялангуяа эрт үеийн холбогдолтой эх хувь газрын зургуудыг бодлогоор цуглуулж улсын музейн сан хөмрөгийг баяжуулах шаардлагатай байна.

Соёлын өвийн улсын нэгдсэн бүртгэл-мэдээллийн сан цаашдаа зөвхөн музейгээс гадна төрийн болон орон нутгийн өмчит түүх, соёлын дурсгалт зүйл байж болох 150 орчим байгууллагын мэдээллийг улсын санд нэгтгэх, хүлээн авах зорилготой ажиллаж байна.

Хавсралт

Соёлын өвийн УНБМСанд бүртгэгдсэн музейнүүдийн сан хөмрөг дэх газрын зургийн тухай бүртгэлийн мэдээлэл

№	Эзэмшигч музей	Газрын зураг	Хэмжээ	Материал арга ажиллагаа	Хэдий үед бүтээгдсэн
1	Монголын Үндэсний музей	Монголын аялалын замыг харуулсан газрын зураг. 1:2500000 масштабтай. Өнгөт хэвлэл.	Өргөн: 98 см, Өндөр: 50 см	Цаас үйлдвэр	2003 он
2-8		Газрын зураг, Өнгөт хэвлэл. 8 өөр	Өргөн: 67 см, Өндөр: 45 см	Цаас үйлдвэр	
9		Хадаг, газрын зураг Японы пансан алчуур-1ш, 2ш хадагтай	урт-70 см, өргөн-67 см	торго. Гар хийц	

10	Монголын Үндэсний музей	БНМАУ-ын аж үйлдвэрийн байршилтын зураг, хулдаасан дээр зурсан монголын аж үйлдвэрийн байршилтыг харуулсан газрын зураг	Өргөн: 148 см, Өндөр: 100 см	Хулдаас	
11		Улиастайн газрын зураг, Цагаан даавуун дээр хар өнгөөр план хэлбэртэй зурсан.	Урт: 238 см, Өндөр: 123 см	Даавуу	
12		Цаасан дээр хэвлэсэн, БНМАУ-ын газрын зураг.	Урт: 179.5 см, Өргөн: 102 см	Цаас хэвлэмэл	
13		Арьсан дээр зурсан газрын зураг, фото зургийн хамт, Арьсан дээр Монгол улсын газрын зураг, жаазтай фото зураг. Эверестийн оргил дээр уг газрын зургийг, уулын спортын мастер Б.Гангаамаа авч гарсан.	/урт 40 см, өргөн 50 см, 2/ урт 58 см, өргөн 109 см.	Гар хийц	
14		1927 оны монголын газрын зураг ногоон өнгөөр монгол улсын газрын зургийг тэмдэглэсэн хуучин монгол бичгээр үгийг бичсэн 1:2000000	өндөр-93 см, өргөн-150 см	Үйлдвэр	
15		Газрын зураг 1937 он			
15		Газрын зураг (Их юань улс)	91x129	гар зураг	
16		Газрын зураг (Дай Ляо, Хятан улс)	102x53	гар зураг	
17		авто замын сүлжээний газрын зураг	урт-121 см, өргөн-61 см	цаас. Үйлдвэр	2006 он
18		Газрын зураг (хошууны газрын зураг), Муутуу цаасан дээр ногоон өнгөөр уул, мод зэргийг дүрслэсэн, хар өнгийн бэхээр хуучин монгол бичгээр үгийг бичсэн.	Урт: 81см, Өндөр: 35см	Гар хийц цаас	Өвөрмонголоос нүүж ирэхэд нь олгосон хошууны зургийг Сумьяа бэйс зурсан.
19		Газрын зураг (БНМАУ-ын зам харилцааны зураг) зам харилцаа болон хилийг харуулсан өнгөт хэвлэл	Өргөн: 107 см, Өндөр: 72 см	үйлдвэр цаас	Геодизи зураг зүйн газар
20		Газрын зураг (БНМАУ-ын аялал жуулчлалын хэвлэмэл Монголын газрын зураг дээр дүрслэсэн	Өргөн: 102см, Өндөр: 67см	үйлдвэр цаас	Геодизи зураг зүйн газар
21		Байгаль, хөдөө аж ахуйн газрын зураг өнгөт газрын зураг монголын газрын зурган дээр өнгөтөөр тэмдэглэсэн тэмдэглэгээ хийсэн оросоор хэвлэсэн	Өргөн: 105 см, Өндөр: 67 см,	үйлдвэр	хэвлэх үйлдвэр хэвлэсэн
22		БНМАУ-ын газрыг зураг дээр өнгөтөөр ашигт малтмалын байрлалыг тэмдэглэсэн өнгөт хэвлэл	Өргөн: 170 см, Өндөр: 94 см	үйлдвэр цаас	Геодизи зураг зүйн газар
23		Газрын зураг (Уйгар улс) ватум цаасан дээр усан будгаар зурсан үгийг хар өнгөөр бичсэн	Өргөн: 109 см, Өндөр: 60 см	гар зураг	
24		Газрын зураг (Түрэг улс) ватум цаасан дээр усан будгаар зурсан	Өргөн: 101см, Өндөр: 56 см	гар зураг	1978 он

25	Монголын Үндэсний музей	А.Симуковын зураг өнгөөр ялган зурсан, хэвлэмэл	Өргөн: 69 см, Өндөр: 45 см		50796 2008-1-142
26		Дархан, Булган аймгийн газрын зураг. Өнгөт хэвлэл.	Өргөн: 92 см, Өндөр: 54 см	цаас, хэвлэмэл	
27		Газрын зураг. Ю.Цэдэнбал хүү Славкад бэлэглэсэн.	Өргөн: 128 см, Өндөр: 93 см, Үнэт чулууны тоо ширхэг: 1	Өнгөт хэвлэл	
28		Монгол улсын Баруун өмнөд хэсгийн зураг.	Өргөн: 60 см, Өндөр: 71 см	цаас, өнгөт хэвлэл.	
29		Газрын зураг "Өвөрхангай аймаг", Цаасан дээр өнгөтөөр хэвлэсэн. Хэвлэмэл, Маш нарийн тэмдэг хийсэн, нарийвчлал өндөртэй.	Өргөн: 145 см, Өндөр: 95 см	цаас	1954 ?
30		Газрын зураг "БНМАУ-ын газрын зураг", Өнгөтөөр хэвлэсэн, газрын зураг дээр дүрсэлсэн 1:5000000 масштабтай. "Улс бүхэнд судар бий, айл бүхэнд түүх бий" бичлэгтэй	Өргөн: 170 см, Өндөр: 95 см	өнгөт хэвлэл	ШУА-с 1959 онд хэвлүүлсэн.
31		Газрын зураг Уйгар улс, Ватум цаасан дээр усан будгаар зурсан.	Өргөн: 108 см, Өндөр: 60 см	цаас, гар зураг	
32		Газрын зураг Жужан, Ватум цаасан дээр усан будгаар зурсан.	Өргөн: 105 см, Өндөр: 64 см	цаас, будаг, гар зураг	
33		Газрын зураг Монгол аймаг, ватум цаасан дээр усан будгаар зурсан.	Өргөн: 105 см, Өндөр: 60 см	цаас, гар зураг	
34		Газрын зураг Ватум цаасан дээр усан будгаар зурсан. 12-р зууны монгол аймгууд.	Өргөн: 106 см, Өндөр: 60 см	Цаас гар хийц	1978 он
35		Газрын зураг Ватум цаасан дээр усан будгаар зурсан.	Өргөн: 105 см, Өндөр: 65 см	Цаас гар хийц	1978 он
36		Газрын зураг "Хятан улс 987-1125 он" Өнгөтөөр хэвлэсэн, газрын зураг дээр дүрсэлсэн 1:5000000 масштабтай.	Өргөн: 82 см, Өндөр: 60 см	цаас, үйлдвэр	Улсын хэвлэлийн комбинат
37		Газрын зураг "Түрэг улс 552-745 он" Өнгөтөөр хэвлэсэн, газрын зураг дээр дүрсэлсэн 1:5000000 масштабтай.	Өргөн: 82 см, Өндөр: 60 см	цаас, үйлдвэр	Улсын хэвлэлийн комбинат
38		Газрын зураг "Сяньби улс V-IV зуун" Өнгөтөөр хэвлэсэн, газрын зураг дээр дүрсэлсэн 1:5000000 масштабтай.	Өргөн: 82 см, Өндөр: 60 см	цаас, үйлдвэр	Улсын хэвлэлийн комбинат
39	Газрын зураг "Уйгар улс 745-840" Өнгөтөөр хэвлэсэн, газрын зураг дээр дүрсэлсэн 1:5000000 масштабтай.	Өргөн: 82 см, Өндөр: 60 см	цаас, үйлдвэр	Улсын хэвлэлийн комбинат	

40	Монголын Үндэсний музей	Газрын зураг БНМАУ-ын байгалийн хамгаалалтын зураг цаасан дээр хэвлэсэн өнгөт хэвлэл	84x102	цаас, үйлдвэр	Улсын хэвлэлийн комбинат 1985 он
41		XX зууны эхэн үеийн монголын нийслэлийн зураг.	Өргөн: 100 см, Өндөр: 64 см	Цаас	
42		Газрын зураг БНМАУ-ын ерөнхий эдийн засгийн зураг. 1:2500000 масштабтай өнгөт зураг.	Өргөн: 100 см, Өндөр: 70 см	цаас, үйлдвэр	Улсын хэвлэх үйлдвэрт
43		Газрын зураг БНМАУ-ын барилгын материалын үйлдвэр. 1:2500000 масштабтай өнгөт зураг.	Өргөн: 100 см, Өндөр: 70 см	цаас, үйлдвэр	Улсын хэвлэх үйлдвэрт
44		Газрын зураг "Эдийн засгийн төв муж" Өнгөт хэвлэмэл зураг.	Өргөн: 82 см, Өндөр: 108 см	цаас, үйлдвэр	1985 он
45		Газрын зураг Цаасан дээр хэвлэсэн өнгөт хэвлэл. "БНМАУ-ын м.а.а-н зураг"	Өргөн: 107 см, Өндөр: 70 см	цаас, үйлдвэр	
46		Газрын зураг "Монголын байлдан дагуулал" Цаасан дээр хар түшээр зурсан.	Өргөн: 123 см, Өндөр: 91 см	цаас, гар зураг	1984 он
47		"1925 оны засаг захиргааны хувиарь" газрын зураг	Өргөн: 102 см, Өндөр: 58 см	цаас	1983 онд хэвлэсэн.
48		Цаасан дээр хэвлэсэн өнгөт хэвлэл. "Улаанбаатар хотын" газрын зураг	Өргөн: 67 см, Өндөр: 53 см	цаас, үйлдвэр	Улсын хэвлэлийн комбинат.
49		Газрын зураг "Хүннү улс МЭӨ 209-МЭ 93" Өнгөтөөр хэвлэсэн, газрын зураг дээр дүрсэлсэн 1:5000000 масштабтай	Өргөн: 83 см, Өндөр: 60 см	цаас, үйлдвэр	Улсын хэвлэлийн комбинат.
50		Газрын зураг, Говь-Алтайд тарилгын үзүүлэлт харуулсан. Хулдаасан дээр Говь-Алтай аймгийн зургийг хэвлэж тэмдэглэгээ хийсэн.	Өргөн: 94 см, Өндөр: 116 см	хулдаас, үйлдвэр	
51		Цаасан дээр өнгөтөөр хэвлэсэн хэвлэмэл, өнгөт зурагтай. Монгол улсын засаг захиргааны хувиарын газрын зураг.	Өргөн: 104 см, Өндөр: 57 см	цаас	
52		Цаасан дээр хэвлэсэн өнгөт хэвлэл. "БНМАУ-ын хүн амын газрын зураг"	Өргөн: 103 см, Өндөр: 71 см	цаас, үйлдвэр	
53	Газрын зураг "БНМАУ-ын хүн амын зураг", Өнгөт хэвлэл, дээрээ БНМАУ-н газрын зурагтай, доод талд нь үндэстэн ястаныг цувуулан хэвлэсэн. Дээрээ тэмдэглэгээ хийсэн.	Өргөн: 102 см, Өндөр: 70 см	цаас, үйлдвэр	Улсын геодези зурагзүйн газар. 1985 он	

54		Газрын зураг Монгол улсын засаг захиргааны хуваарийн тухай. Хэвлэмэл	Өргөн: 69 см, Өндөр: 47см	цаас, үйлдвэр	1931 оны Монгол улсын газрын зураг. Симуков хэвлүүлсэн 104387 99-1-1
55	Монголын Үндэсний музей	Симуковын газрын зураг, Цаасан дээр хэвлэсэн зураг. Монголын м.а.а, хүн ам, засаг захиргаа, зэргийг харуулсан. 1924 онд зохиогдсон 18 зурагтай.		цаас	1004388 2002-4-9
56		Газрын зураг, Ватум дээр өнгө ялгаж зурсан. Дээр нь 18638, 18644, 18641, 18629, 18639 гэсэн шифртэй. -5ш	Өргөн: 64 см, Өндөр: 53 см	цаас	
57		Жүгдэрийн зурсан “Нийслэл хүрээ” монгол зураг XX зууны эхэн үеийн Нийслэл хүрээг план зургаар зурж дээр нь хүрээ хийд, газар усны нэрийг монгол үсгээр бичиж гэмдэглэсэн.	58x103 см,	Даавуу, шороон будаг	1912 он
58	Богд хааны ордон музей	Хайстай Лаврин (VIII Богд хааны зуны ордоны план зураг)	158x188 см	Даавуу, шороон будаг	XX зууны эх
59		Богдын Ногоон ордон	158x188 см	Даавуу, шороон будаг	XX зууны эх
60		Газрын зураг			XXзууны эхэн үе 1122БОМ2536 1/8/2001/
61		Газрын зураг			БНМАУ-ын үе (1924-1992 он) 1122БОМ2537 1/8/2002/
62	Байгалийн түүхийн музей	“Монгол улсын газрын зураг” (Симуковын ногоон) Хар ногоон өнгийн дэвсгэр дээр газар нутгийн нэрийг уйгаржин монгол бичгээр хар өнгөөр бичсэн	Урт: 121 см, Өндөр: 89 см	хэвлэмэл зураг	XX зууны эхэн үе
63		Загасны тархалтын газрын зураг	Урт: 99 см, Өндөр: 52 см	хэвлэмэл зураг	XX зуун
64		Ан амьтны тархалтын газрын зураг	Урт: 99 см, Өндөр: 52 см	хэвлэмэл зураг	XX зуун

65	Улаанбаатар хотын музей	ХIХ зууны сүүл үеийн Их хүрээний байдал ХIХ зууны сүүл үеийн буюу хувьсгалын өмнөх Их хүрээний сүм дуган дацан, аймаг, жас, том ноёдын хашааны байршлыг харуулсан зураг бөгөөд тэдгээр байршлыг тоогоор тэмдэглэн тайлбар зүүж бичсэн нь тухайн үеийн Их Хүрээний бүтэц, зохион байгуулалт, байршлыг тодруулан гаргахад судалгааны томоохон хэрэглэгдэхүүн болж байгаагаараа ач холбогдолтой.	149x149 см	Цаас, гуашь, усан будаг.	1956 он
66		Нийслэл хүрээ 1912 онд Жүгдэрийн зурсан “Нийслэл хүрээ” хэмээх зургийг 1946 онд зураач Манибадар хуулбарлан томруулж зурсан бөгөөд үг бүтээлээс ялгарах гол онцлог нь ХIХ зууны сүүл, ХХ зууны эхэн үеийн Их хүрээний дүр төрхийг нарийн дүрсэлж, бүтэц зохион байгуулалтыг уран зургийн аргаар ялган гаргасан зураг юм.	148x282 см	Даавуу, гуашь.	1946 он
67		Эзэнт гүрний үеийн зоосны газрын зураг-1			Юан гүрний үе (1271-1368 он) 1119ТТМ48 ТО8ЛЛ085-01
68		Эзэнт гүрний үеийн зоосны газрын зураг-2			Юан гүрний үе (1271-1368 он) 1119ТТМ72 ТО8ЛЛ086-01
69	Төрийн түүхийн музей	Монгол аймгууд газрын зургууд			Монгол Улсын үе (1992 оноос хойш) 1119ТТМ363 ТО7С349-01
70		Олноо өргөгдсөн Монгол Улс газрын зураг			Монгол Улсын үе (1992 оноос хойш) 1119ТТМ366 ТО7С350-01
71	БХЯамны харьяа Монгол цэргийн музей	Газрын зураг-Монголын эзэнт гүрэн			1110МЦМ351 Ү-96-10-18
72		Чингис хааны үеийн хамаарах Монголын газрын зураг	Өргөн:45.5 см, Өндөр: 62 см	Ватум цаасан дээр зурсан	ХХ зууны сүүл ХХI зууны эхэн үе
73	Архангай аймгийн музей	Архангай аймаг дахь археологийн дурсгалт газруудыг харуулсан.	Ург: 233 см, Өндөр: 149 см	Хэвлэмэл	
74		Заяын хүрээ	84x59.5 см	Цаас, гуашь	1958 он

75	Архангай аймгийн Тариат сумын ОНСТ	Тариат сумын газрын зураг	Өргөн: 152.5 см, Өндөр: 90 см	Нимгэн модон дээр зурсан	БНМАУ-ын үе (1924-1992 он)
76	Архангай аймгийн Цэнхэр сумын ОНСТ	Сумын газрын зураг (Сумын төв, багийн төв, сумын хил, гол нуур, авто машины замыг дүрсэлсэн)	Урт: 107 см, Өндөр: 151 см	Ватум цаасан дээр зурсан	БНМАУ-ын үе (1924-1992 он)
77	Баян-Өлгий аймгийн музей	Аймгийн газрын зураг	200x300 см,	Цаасан дээр зурсан	1960-аад он
78	Баянхонгор аймгийн музей	Монгол улсын өндөр нам уул усны газрын зураг	45x68 см,	Цаас	1930 он
79		Сайн ноён хан аймгийн хошуудын зургийг харуулсан схем зураг (одоогийн Баянхонгор аймаг)	Өргөн: 67 см, Өндөр: 100 см	Нимгэн мод	1970 он
80		Монгол Улсын газрын зураг			Богд Хаант Монгол улсын үе (1911-1924 он) 97-2-1
81		Монголын газрын зураг	Өргөн: 79 см, Өндөр: 33 см	Модоор хийсэн	
82	Булган аймгийн музей	Булган аймгийн ерөнхий газрын зураг.	Өргөн: 93.5 см, Өндөр: 145.5 см	Хэвлэмэл	БНМАУ-ын үе (1924-1992 он)
83	Говь-Алтай аймгийн музей	Говь-Алтай аймгийн газрын зурагтай самбар Ватум цаасан дээр гуашаар хийсэн. 2 ширхэг. 1. Аймгийн газрын нэрээр нэрлэсэн тухай, 2. Говь-Алтай аймаг	Урт: 58 см, Өргөн: 86 см	Цаасан дээрээр гараар зурсан	
84-98		Говь-Алтай аймгийн музей	Говь-Алтай газрын зураг, 1. Физик газар зүйн зураг, 2. Эрүүлийг хамгаалах газар, 3. Эдийн засгийн байршил 4. Боловсрол 5. Соёлын байгууллага 6. Засаг захиргааны хуваарь 7. Хөдөө аж ахуй, 8. Хүн ам угсаатан зүй 9. Байгаль хамгаалал 10. Уур амьсгал 11. Хөрс ургамал 12. Ан амьтан газар зүй 13. Газрын нас судлал 14. Ургамалжилт 15. Аймгийн нутаг дэвсгэрийн зураг Улсын геодези зураг, зүйн газар гэсэн тамгатай	Урт: 95 см, Өргөн: 125 см	Цаас, будаг, үйлдвэрийн

99	Говь-Алтай аймгийн музей	Ашигт малтмалын үнэт чулуун дурсгал газрын зураг Засаж өнгөлсөн тэгш өнцөгт хэлбэртэй боржин чулуун дээр бор өнгийн чулуугаар аймгийн газрын зургийг дүрсэлсэн. Ашигт малтлын тархац бүхий газрыг өөр өөр өнгийн чулуугаар нааж тогтоон, доор нь ашигт малтмалын нэрийг гуулиар бичсэн.	50x65.5x2см,	Саарал өнгийн боржин чулуу, гууль.	Говь-Алтай аймгийн харьяат геологичид 1990 он
100		МАХН-н 50-н жилд зориулсан газрын зураг			БНМАУ-ын үе (1924-1992 он) 8201ГАМ523 ГА.Т78,46
101		Хувьсгалт залуучуудын эвлэл 50-н жилийн газрын зураг			БНМАУ-ын үе (1924-1992 он) ГА.Т78,48 8201ГАМ529
102		Хүннү газрын зураг			Монгол Улсын үе (1992 оноос хойш) 03,14 4501ДАМ280
103		Сяньби улсын газрын зураг			Монгол Улсын үе (1992 оноос хойш) 03,15 4501ДАМ281
104	Дархан-Уул аймгийн музей	Түрэг улсын газрын зураг			Монгол Улсын үе (1992 оноос хойш) 03,16 4501ДАМ282
105		Уйгар газрын зураг			Монгол Улсын үе (1992 оноос хойш) 03,17 4501ДАМ283
106		Хятан газрын зураг			БНМАУ-ын үе (1924-1992 он) 03,18 4501ДАМ284
107		Монгол газрын зураг			БНМАУ-ын үе (1924-1992 он) 3.19 4501ДАМ741
108	Дорнод аймгийн музей	Дорнод аймгийн ашигт малтмалуудын байршлыг тусгай дүрсээр тэмдэглэж хийсэн.	Урт: 110 см, Өндөр: 80 см	Мод, цаас, даавуу	1970 он

109		Илдэн вангийн хошууны газрын зураг. Хонины арьсны дотор талд хар өнгийн бэхээр газар нутгийн нэрийг бичиг тэмдэглэсэн. Гадна талаараа модон жаазтай. арьсыг нарийн утсаар тал талаас нь бэхэлж тогтоосон. Зургийн дээд талд монгол бичгээр Илдэн вангийн хошууны газрын зураг гэж бичсэн.	Урт: 90см, Өндөр: 110см	Арьс, мод Гар аргаар	2005 он
110	Дорнод аймгийн музей	БНМАУ-ын газрын зураг гэж монгол бичгээр зүүн доод буланд бичсэн, таван аймагт хуваан өнгөөр ялгасан, шар өнгө-Алтайн хязгаар, ягаан өнгө-Хантайшир уулын аймаг, ногоон өнгө-Цэцэрлэг мандал уулын аймаг, саарал өнгө-Богд хан уулын аймаг, хул шар өнгө-Хан хэнтий уулын аймаг гэж монгол бичгээр бичсэн.	84x125 см	Цаас Үйлдвэрийн аргаар	Германд хэвлэсэн. 1926 он
111		Санбэйсийн хүрээний зураг	126x1786 см	Даавуу, усан будаг	
112		Сэцэн хан аймгийн газрын зураг			БНМАУ-ын үе (1924-1992 он) 89-03 2101ДОМ1054
113		Хан Хэнтий уулын аймаг (газрын зураг)			БНМАУ-ын үе (1924-1992 он) 89-13 2101ДОМ796
114	Дорнод аймгийн Баяндун сумын ОНСТ	БНМАУ-ын газар нутгийн зураг, газар нутгийн нэрийг монгол бичгээр бичсэн. 1924 он	Урт: 120 см, Өндөр: 84 см	Хэвлэмэл	1924 он
115		Даавуун дээр Монгол орны газрын зургийг хээн дотор оруулж зурсан.	Урт: 119 см, Өндөр: 76 см	Даавуу	БНМАУ-ын үе (1924-1992 он)
116	Дорноговь аймгийн музей	Монголын газрын зураг	Урт: 134.5 см, Өндөр: 77 см	Хэвлэмэл	БНМАУ-ын үе (1924-1992 он)
117		Аймгийн ан амьтан газрын зураг	Урт: 109 см, Өргөн: 75 см	Цаас, гар арга.	БНМАУ-ын үе (1924-1992 он)
118		Дорноговь газрын зураг,		Цаас	БНМАУ-ын үе (1924-1992 он)
119	Дорноговь аймгийн Алтанширээ сумын ОНСТ	Сумын газрын зураг		Эслэг хавтан	1980 он
120	Дорноговь аймгийн Иххэт сумын ОНСТ	Сумын газрын зураг	Урт: 198 см, Өргөн: 144 см	Нимгэн модон дээр зурсан	
121	Дорноговь аймгийн Хөвсгөл сумын ОНСТ	Сумын газрын зураг	Өргөн: 86 см, Өндөр: 61 см	Нимгэн модон дээр зурсан	

122	Дундговь аймгийн музей	Дайчин бээсийн хошууны нутгийн хилийн газрын зураг	63x78 см	Даавуу, бэх	XVII зуун
123		Боржигин сэцэн вангийн хошууны зураг	50x30 см	Цаас	XVII зуун
124		Харчин өртөөний зураг (орчин үед сэргээн зурсан)		Цаас, гараар зурсан	XX зуун
125	Завхан аймгийн музей	Улиастай хотын схем Уг зургийн доод талын хэсэгт уйгаржин монгол бичигээр 1923 оны Улиастай хот гэсэн бичигтэй. Цагаан өнгийн ямбуун дээр хар өнгийн тушиэр план зургийн аргаар зурсан.	160x300 см	Цагаан ямбуу, хар өнгийн туши.	1950 он
126		Завхан аймгийн газрын зураг			Монгол Улсын үе (1992 оноос хойш) 93-01 81013AM204
127	Орхон аймгийн музей	Нэг мянга есөн зуун хорин долоон оны монголын газрын зураг Цаасан дээр буулгасан хэвлэмэл 1927 оны монголын газрын зураг, монголын хилийн цэс, уул, ус, газар байдлын нэрсийг тодорхойлон бичиж, өнгөөр ялгасан зураг. хуучин монгол бичгээр бичсэн бичиглэлтэй. цаасан дээр зургийг буулгаж даавуугаар ар хийсэн.	Урт: 120 см, Өргөн: 84 см	цаас, даавуу (үйлдвэрийн арга)	X зууны эхэн үе 1927 он
128	Өвөрхангай аймгийн музей	Хөдөө аж ахуй газрын зураг Өвөрхангай аймгийн сумдуудын хөдөө аж ахуйн эдэлбэр газар тариалсан газрын талбайн хэмжээ, тариалангийн талбайн төрөл зэргийг газрын зурагт нарийн харуулсан.	Урт: 86 см, Өргөн: 60.5 см,	ватум цаас, будаг	XX зууны дунд үе
129	Өвөрхангай аймгийн Сант сумын ОНСТ	Сумын газрын зураг	Урт: 60 см, Өргөн: 80 см	Хөөсөнцөр	XX зууны сүүл үе
130	Өмнөговь аймгийн музей	БНМАУ-ын газрын зураг /1924/ А.Д.Симуковын 1924 онд зохиосон газрын ногоон зураг уйгаржин бичгээр аймаг, хошуу нутгийн нэрийг бичсэн.	жаазгүй у 107,5 см өр 75 см	цаас будаг, шил, жааз үйлдвэр	XX зууны эхэн үе 1924 он
131		Монгол улсын газрын зураг	у 144 см , өр 120 см,	цаас, үйлдвэр	1960 он
132		Газрын зураг, Цайвар ногоон дэвсгэр дээр гушаар зурсан , хөх ягаан даавуугаар бүрсэн жаазтай Өмнөговь аймгийн засаг захиргааны хуваарийн зураг	өн 56,8 см, өр 81 см	цаас, гуаш, хуулбар	1970 –аад он

133	Өмнөговь аймгийн музей	Газрын зураг Хүй нэгдлийн нийгмийн үе	жаазгүй өн 58,5 см, өр 84,5 см	цаас, гуаш, шил, мод, даавуу, хуул- бар, гар арга	
134		Газрын зураг Өмнөговьд байсан манжийн үеийн өртөөнүүд	жаазгүй өн 58,5 см, өр 84,5 см	цаас, гуаш, шил, мод, даавуу, хуул- бар, гар арга	
135		Газрын зураг Богд хаант автономит монгол улс	жаазгүй өн 68,5 см, өр 83,5 см	цаас, гуаш, шил, мод, даавуу, хуул- бар, гар арга	
136		Газрын зураг Монгол Ардын хувьсгалын ялалт	жаазгүй өн 59,5 см, өр 84,2 см	цаас, гуаш, шил, мод, даавуу, хуул- бар, гар арга	
137		Газрын зураг Минеральны вод	өн 62 см, өр 98 см	Цаас, үйлдвэр	Хэвлэлийн үйлдвэр
138		Газрын зураг Ургамалжилт	Өн 63,5 см, өр 104,5 см	Цаас, үйлдвэр	
139		Газрын зураг Ашигт малтмалын зураг		Цаас, үйлдвэр	
140		Газрын зураг Дорнод муж карт эдийн засгийн дорнод муж карт.	Өн 104,5 см, өр 84 см	Цаас, үйлдвэр	1980-аад он
141		Газрын зураг Монгол Улсын газрын зураг	Өн 71 см, өр 107 см	Цаас, үйлдвэр	1980-аад он
142		Аялал жуулчлалын бүсчлэл болон авто замын тодорхой заасан газрын зураг Иж бүрдэл үзмэрийн	өн 119 см, өр 167 см	Цаас, үйлдвэр	2009 он
143	Өмнөговь аймгийн Баяндалай сумын ОНСТ	Сумын газрын зураг	Өн 109 см Өр 40.6 см	Цаас, усан будаг, мод, гар арга	БНМАУ-ын үе (1924-1992 он)
144	Өмнөговь аймгийн Ханбогд сумын ОНСТ	Монгол улсын газрын зураг хэлбэртэй чулуу (байгаль эх)	У 12 см Өр 6 см	Чулуу	
145	Сэлэнгэ аймгийн музей	Газрын зураг, Фото хулдаасан дээр эх зургаас нь фото аргаар хуулбарлан хэвлэсэн зураг .	Урт:110 см, Өргөн: 90 см	Хулдаас	XX зууны сүүл үе
146		Сэлэнгэ газрын зураг Манж чин улсын үе 1691-1911 гар аргаар хийсэн.	Өргөн:100 см, Өндөр: 75 см	Хөөсөнцөр, хуулга	XX зууны дунд үе
147		Сэлэнгэ газрын зураг Богд хаант засгийн үеийн 1911-1924 он гар аргаар хийсэн.	Өргөн: 100 см, Өндөр: 75 см	Хөөсөнцөр, хуулга	XX зууны дунд үе
148		Сэлэнгэ газрын зураг Ардын засгийн үе 1925-1931 он, гар аргаар хийсэн.	Өргөн: 100 см, Өндөр: 75 см	Хөөсөнцөр, хуулга	XX зууны дунд үе

149		Төв аймгийн байгаль хамгаал- лын Газрын зураг	Урт: 115см, Өргөн: 75см	цаас, хөнгөн цагаан	XX зууны сүүл үе
150	Төв аймгийн музей	Богд хан уулын аймгийн газрын зураг. гараар зурсан, газрын зураг, аймгийн яамны байшин, хар цагаан гэрэл зургийн хамт	Урт: 120см, Өргөн: 81.5см	циллиод, цаас	XX зууны сүүл үе
151		Монголын эзэнт гүрний газрын зураг	Урт: 48см, Өргөн: 83см	цаас	XXI зууны эхэн үе
152	Төв аймгийн Дэлгэрхаан сумын ОНСТ	Дэлгэр хаан сумын газрын зураг, Цаасан дээр гуашаар зурсан,	Өргөн: 61см, Өндөр: 86см	цаас, гуаш	
153	Төв аймгийн Сүмбэр сумын ОНСТ	Сүмбэр сумын газрын зураг Эсгийн дээр дугуй дотор газрын уралсан модон хүрээтэй	Урт: 62см	эсгий мод гар арга	
154	Төв аймгийн Угтаалцайдам сумын ОНСТ	Сумын газрын зураг	Өргөн: 180см, Өндөр: 120см	целлиод, хуулга	
155		Монгол орны газрын зураг, 1:2500.000-н масштабтай газрын зураг	Өргөн: 102 см, Өндөр: 55 см	Цаас хэвлэмэл	XX зууны дунд үе
156	Увс аймгийн музей	Монголын феодолийн нэгдсэн улсын газрын зураг, Энэ үеийн газрын зургийг хуулбарлаж зурсан зураг	Өргөн: 99 см, Өндөр: 65 см	цаас гар аргаар	
157		Ойрад улсын газрын зураг, Ватум цаасан дээр ногооноор будаг хар бэхээр зурсан хуулбар зураг	Өргөн: 100 см, Өндөр: 50 см	Цаас бэх бийр гар аргаар	
158	Увс аймгийн Хяргас сумын ОНСТ	Хяргас сумын газрын зураг, 1. Сумын ашигт малтмалын байршилыг дүрсэлжээ. 2. сумын газрын зураг дээр засагш захиргааг тэмдэглэжээ.			
159	Увс аймгийн Тариалан сумын ОНСТ	байгалийн үзэсгэлэн газрын зураг, уул ус аргалууд дүрсэлжээ.	Урт: 76 см, Өндөр: 56 см	цасан дээр усан будагаар зурсан.	
160	Увс аймгийн Өмнөговь сумын ОНСТ	Өмнөговь сумын газрын зураг гипсээр Өмнөговь сумын газрын зураг уул, ус гол мөрний товойлгон сийлсэн.	Өргөн: 103 см, Өндөр: 177 см	Гипс гар арга	
161		Монгол нутагт үүссэн анхны төрт улсуудын газрын зураг, Монгол нутагт үүссэн Хүннү, Сяньби улсуудын газар нутгийн зохион байгуулалт, хил хязгаар овгуудын нүүдлийн маршрут зам харилцаа хотууд овог аймгуудын нутаг дэвсгэрийг харуулсан байна.	Өргөн: 138 см, Өндөр: 102 см	Бор өнгийн эслэг хавтан ватум цаас бэх	XX зууны сүүл үе
162	Ховд аймгийн музей	Манж чин улсаас баруун монголыг колончилж байсан нь (газрын зураг), Манж чин улсын үед баруун монголын оршин тогтнож байсан хил, хязгаар хиллэж байсан улс гүрнүүд болон томоохон хотуудыг гараар зурж бүтээсэн.	Өргөн: 80 см, Өндөр: 60 см	Ватум цаас, хар хүрэн цэнхэр өнгийн усан будаг,	

163		Цэцэрлэг сум нутгийн (газрын зураг) Газар зүйн байрлал, хил хязгаар уул, нуруу, гол мөрөн дүрсэлсэн. Монгол бичгээр бичсэн.	60x90 см	усан будаг, ямбуу, жааз шилтэй.	1925-1930 он
164	Хөвсгөл аймгийн музей	Монгол орны газрын зураг, Засаг захиргааны нэгжийг 4-н уулаар нь нэрлэж, уйгаржин монгол бичгээр бичсэн газрын зураг.	90x124 см	даавуу, хэвлэмэл	Ардын гэгээрүүлэх яам Герман Лейгциг 1920 он
165		Цагаантныг бут цохисон газрын зураг. МАЖЦэрэг Улаан цэргийн давшилтын газрын зураг.	54x27 см	цаас, усан будаг.	
166	Хөвсгөл аймгийн Бүрэнтогтох сумын ОНСТ	Бүрэнтогтох сумын газрын зураг (гэрэлт самбар) Шилэн дээр сумын газрын зургийг өнгө ялган харуулж, арын фонд нь Дэлгэр мөрөн голыг оруулан зурсан байна.	у-65 см өр-65 см өн-21 см	Банз, паннер, шил	1980-аад он
167		Далай гүний хошууны газрын зураг, Модон хайрцаг шилэн нүүрэн дээр өнгө будаг ялган зурсан. 1921-1923 он далай гүн хошуу гэсэн бичигтэй.	65x21x65	Банз паннер, шил,гэрэл	1980 он
168		Манжийн дарлалын үеийн Сэцэн хан аймаг газрын зураг Сэцэн хан аймгийн тухайн үеийн 24 хошууны газар нутгийн өнгө ялган тасархайг шугамаар дүрсэлжээ. Газрын зургийг монгол үндэсний хээ болох алхан хээгээр хүрээлжээ.	У-200 см Өр-147см	Хулдаас, будаг, гар аргаар зурсан.	БНМАУ-ын үе / 1924 - 1992 он / зурсан.
169	Хэнтий аймгийн музей	"Хэнтий аймгийн газрын зураг" гэрэлт самбар, Хул шар өнгөтэй, хүрэн өнгөөр аймгийн нутаг дэвсгэрийг зурж, засаг захиргааны нэгжүүдийг зааглан дүрсэлсэн. Гэрэл суулгасан нүхтэй. Дээр нь "Хэнтий аймаг" гэсэн бичигтэй.	Өргөн:150 см, Өндөр: 200 см,	Хавтан, хуулга, будаг Гараар зурж бүтээсэн	
170		Сэнгүр горхины түүхэн дурсгалт газрын зураг			БНМАУ-ын үе (1924-1992 он) 90-33-2 2301ХЭМ721
171		Дэлүүн болдог түүхэн дурсгалт газрын зураг			БНМАУ-ын үе (1924-1992 он) 90-33-3 2301ХЭМ723

172	Хэнтий аймгийн Батноров сумын ОНСТ	Хошууны газрын зураг Дээр үеийн Сэцэн хан аймгийн сэргэлэн гүн Дугарсүрэнгийн хошууны бүх нутгийн монгол бичгэн тайлбартай баруун дээд буландаа тамганы тал хэсэгтэй 2 цаас нийлүүлж наасан.	55x41,8 см	Цаас хэвэлмэл	
173	Хэнтий аймгийн Дадал сумын ОНСТ	Монгол цэргийн Ханлиг аймгийн газрын зураг Хар бэхээр газар усны нэрийг хуучин монгол бичгээр бичсэн	Урт- 180 см Өргөн - 90 см	Гар аргаар мод, цаас, будаг	Монгол улсын үндэсний музейд хэрэглэж байсан

SUMMURY

Exhibits and artifacts, kept in the database of Mongolian cultural heritage and state and local museums are registered in 6 different classifications as natural, archeological, ethnographical, and religious, art and historical values or monuments.

Here we explored the exhibits of maps or geographic mapping of natural areas which are included in the sub-classification of “Document monuments” of “Historic monuments” and as a result of the research we formed a database of mapping documents made in the materials as paper and cotton.

In the treasury of Mongolian museums there are a considerable number of exhibits and artifacts related to ancient and contemporary geographic mapping of Mongolia and its territory. As for April 2015, 173 exhibits of mapping have been registered in the State Registration database of cultural heritage.

In the paper, we described the comprehensive information of the above mentioned 173 maps including the places and dates on which the maps were created, the museums in which the maps are being kept, the territories that are covered on maps, the materials and techniques with which the maps were done and so on.

Generally, as it is seen from the registration of the maps kept in museum funds, there are very few original maps that illustrated social organizations and administrative units of the period before the People’s revolution in 1921 and that illustrated the locations of larger temples and the borders of regions and banners at the time period from mid XVI century to the beginning of XX century.

For many museums, in order to give the cognitive historic knowledge to the audience, there are restored or newly drawn maps of the territories and borders of the ancient states existed in Mongolian territory such as Hunnu, Syanbi, Jujan, Tureg, Yugur, Kidan and Chingis periods of Mongolian Empire and Great Yan Empire.

Most of the mapping exhibits are the maps that illustrated socio-economic branches of socialist period as the maps of administrative units of Mongolian provinces, cities, soums and districts, the maps of demographic and ethnographic groups, geographic zones, distribution of minerals, flora and fauna, and the maps of agriculture, industries, tourism, transportation and other social sectors.

State registration database of cultural heritage is working to register and receive the information and data of locally-owned historic and cultural monuments from over 150 organizations, besides museums.